

АГУУЛГА

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

БҮЛЭГ IV. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ

АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ

ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 30 БҮЛЭГ

X. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ XI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ XII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

БҮЛЭГ XIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ

ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН

СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА


Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	Ширээ уул-2 гөлтгөний орд” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж, байгууллагын нэр:	“Түмэн Тал” ХХК Регистрийн дугаар: 5547938
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Санто Тауэр
Байршил:	Дундговь аймаг, Дэлгэрхангай сум, Ширээ-Уул 2
Утас:	99099048
Мэйл хаяг:	ttumental@gmail.com
Төслийн зорилго:	Ширээ Уул-2 нэртэй талбайн гөлтгөнийн ордыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглаж, аж ахуйн нэгжийн хувьд ажлын байр бий болгох, төслийн ханган нийлүүлэлтэд орон нутгийн иргэд болон аж ахуйн нэгжийг оролцуулахад төслийн зорилго оршино.
Тусгай зөвшөөрлийн дугаар:	МУ-022689
Талбайн хэмжээ:	38,31 га


Төслийн талбайн байршил

Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг
1	104° 20' 47.11"	44° 59' 14.5"
2	104° 20' 20.11"	44° 59' 14.5"
3	104° 20' 20.11"	44° 59' 35.49"
4	104° 20' 47.11"	44° 59' 35.49"

Хүснэгт 1. Ашиглалтын талбайн солбицол



Зураг 1. Ширээ Уул-2 уурхайн байршлийн тойм зураг



Зураг 2. Уурхайн засаг захиргааны зураг

БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Орон нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал:

Хүн ам цөөнтэй, ихэнх нь Дэлгэрхангай сумын төв дээр суурьшин амьдардаг. Гол эрхэлдэг аж ахуй нь нүүдлийн мал аж ахуй. Дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн. Дэлгэрхангай сумын төвд төрийн байгууллагууд ерөнхий боловсролын сургууль,

цэцэрлэг, Хаан банкны салбар, ШТС, соёлын төв, холбоо, дэлгүүр зэрэг ахуй үйлчилгээний байгууллагууд болон өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, Мобиком, Жи- Мобайл, Юнителийн сүлжээнд холбогдсон.

Төсөл хэрэгжүүлж буй талбай нь Монгол Улсын эдийн засгийн төвийн мужийн урд хэсэгт буюу Дундговь аймаг, Өмнөговь аймгийн заагт орших ба дэд бүтэц муу хөгжсөн, төв суурин газруудтай авто машины шороон замаар холбогдсон, холбоо харилцаа, цахилгаан эрчим хүчний системд холбогдоогүй зэлүүд газар байрладаг.

Байгаль орчны төлөв байдал:

Ширээ уул-2 гөлтгөний орд нь геологийн тогтоц, ашигт малтмалын нөөцийн хэмжээгээрээ гөлтгөний ордын нөөцийн ангиллын I бүлгийн 2-р төрөл гэсэн ангилалд хамаарах ба ашигт малтмал агуулсан хурдасны зузаан болон агуулга нь харьцангуй жигд тогтвортой байдаг.

2.1 Уур амьсгал

Дундговь аймгийн хувьд газрын гадаргын хотгор гүдгэрийн ялгаа төдийлэн их биш учраас аймгийн хэмжээгээр уур амьсгалын нөхцөл онцгой ялгардаггүй, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Намрын эхний гэнэтийн хүйтрэлт 10-р сарын дунд 10 хоногт тохиолдох ба зарим үед 9-р сарын дунд буюу эхний 10 хоногт болдог байна. Хүйтрэлгүй хоногийн тоо 125-135 хоногт үргэлжилдэг.

Эх газрын эрс тэс уур амьсгалтай учир хоногийн болон улирлын агаарын температурын хэлбэлзэл ихтэй агаарын дундаж бага температур нь 1-р сард -16.2 хэм, дундаж их температур нь 7-р сард +22.4 хэм байдаг ба жилд дундажаар 80 мм орчим чийг унадаг байна. Тус сум нь говийн бүс хангайн бүсийн дунд оршдог. Өвөлдөө 20-35 хэм хүйтэрч, зундаа 25-32 хэм халдаг. Хавартаа салхи их шуурдаг бөгөөд 5-25м/сек хүрдэг.

2.2 Физик, газар зүй

Тус төслийн талбай нь газар зүйн байршлын хувьд говийн бүсэд хамаарагдах бөгөөд өргөргийн дагуу 1100-1200 м-ийн үнэмлэхүй өндөршилтэй гүвээрхэг, дов толгодорхог гадаргуу үүсгэн тогтсон. Талбайн баруун талд орших Ширээ уулын үнэмлэхүй өндөр 1200 м байна.

Тус район нь говь, хээрийн засварын бүсэд хамаарагдах ба энд тектоник-денудацийн, элэгдэл- хуримтлалын гэсэн хоёр гадаргуу ялгаж болно.

2.3 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл

Судалгааны талбайн районд тархсан газрын доорхи ус нь хөдөлгөөн болон хуримтлалын нөхцөлөөрөө давхрагын, ан цавын гэсэн хоёр төрөлд ялгагдана. Давхаргын ус нь ихэвчлэн дөрөвдөгчийн сэвсгэр хурдсанд агуулагдах ба ус агуулагч хурдас нь хайрга, хайрганцар, элс, элсэнцэр юм.

Ордоос баруун урагш 5км-г орших Цагаан усны уурхайн худаг нь давхаргын ус бөгөөд химийн найрлагаараа гидрокарбонат натрийн ангилалд багтах ба цэнгэгдүү, зөөлөвтөр ус боловч бохирдолт нь ундны усны стандартаас их байна. Ан цавын ус нь дунд рифейн настай хувирмал чулуулаг, дунд севон, доод пермийн настай гүний чулуулаг тархсан талбайд ан цав, тектоник хагарлыг дамжин үүссэн байдаг. Талбайгаас зүүн хойш 13км-т хуучин өрөмдсөн цооногоос ус даралтаас байнга урсан гарч байдаг ба энэ нь ан цавын ус бөгөөд олон жилийн турш хүн, малын ундны хэрэгцээг хангаж байна.

2.4 Хөрс

Говь тал хээрийн завсрын бүсэд багтах ба нунтаг карбонатлаг, хар хүрэн, хүрэн хөрстэй. Талбайн ихэнх гадаргуу жижиг хэмхдэс агуулсан элсэрхэг хөрстэй, хотгор хоолой хэсэгт шаварлаг харс зонхилно.

2.5 Ургамлан бүрхэвч

Хотгор, хоолойнуудаар говийн тачир ургамал/хялгана/, бусад хэсэгт модлог, бутлаг

харгана, шаваг ургасан байна.

2.6 Амьтны аймаг

Ан амьтадаас хар сүүлт, цагаан зээр нүүдэллэн ирдэг ба Дэлгэрхангай ууланд аргал, угалз, янгир ямаа цөөн тоотой байдаг. Махчин амьтдаас чоно, үнэг, хярс, мануул, жижиг мэргэчдээс туулай, алаг даага, орог зусаг, мөлхөгчдөөс хонин ба могой гүрвэл, тогой, монгол бах, жигүүртэн шувуудаас ногтруу, шаазгай, элээ, хэрээ, болжмор, тогоруу байдаг.

БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг байгаль орчин, нийгмийн бүрдэл хэсэг бүрээр үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг.

Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, эрчим, үр дагавар зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх байдлыг үзүүлдэг.

НӨЛӨӨЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД	СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ ҮҮСЧ БОЛЗОШГҮЙ НӨХЦӨЛҮҮД
<p>АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ:</p> <p>- БОХИРДУУЛАГЧ БОЛОН АЮУЛТАЙ, ХОРТОЙ БОДИС ЯЛГАРУУЛАХ, ЭСЭХ - ДУУ ЧИМЭЭ, ДОРГИО ЧИЧИРГЭЭ, ДУЛААНЫ НӨЛӨӨЛӨЛ, ЦАХИЛГААН СОРОНЗОН ЦАЦРАГ ҮҮСГЭХ, ЭСЭХ</p>	<p>Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос шороо болон хорт хий агаар орчныг бохирдуулна. Үүнд: Хөрс хуулах, ашигт малтмал олборлох үед үүсэх тоос Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталгат хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий, дуу чимээ Уурхайн малталтууд болон овоолгуудын талбайгаас салхинд хийсэх тоос Хөрс болон элс тээвэрлэх үед техникийн дугуйнаас босох тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.</p>
<p>УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ: - УСНЫ НӨӨЦӨД ХОМСДОЛ ҮҮСЭХ, ЭСЭХ - ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦИЙГ АШИГЛАХ, ЭСЭХ - УС БОХИРДУУЛАХ, ЭСЭХ</p>	<p>Уурхай болон үйлдвэр технологийн хэрэгцээний усыг гадаргын ус болон гэрээт худгийн усаар хангана. Энэ тохиолдолд газрын гадаргын болон гүний усны нөөцөд тодорхой хэмжээний хомсдол үүсгэх болно.</p>
<p>ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ: - ХӨРС ЭВДРЭХ ЭСЭХ - ХӨРС БОХИРДОХ ЭСЭХ - ХӨРС ДОРОЙТОХ ЦӨЛЖИХ ЭСЭХ</p>	<p>Хөрсний морфологи тогтоц алдагдах, үржил шимт нөөц нь багасах, техногений нөлөөлөл ихсэж, зам харгуй үүсч, хөрс эвдрэх, хөрс хийсэх, дарагдах, талхлагдах зэргээр шинж чанар нь өөрчлөгдөх, Төмрийн хаягдлын цэг дээрээс Зэсийн илэрц гарсан тул суурийг бетондож битүүмжлэл бүхий хог хаягдлын аж ахуйн цэг байгуулах, ШТС болон авто зогсоолын хөрсийг бетондож хөрсний өнгөн хэсэг ахуйн хог болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдохоос сэргийлэх шаардлагатай.</p>

УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ: - УРГАМЛАН НӨМРӨГ, ОЙ МОД ӨРТӨХ ЭСЭХ - ХОВОР, НЭН ХОВОР УРГАМЛЫН ТӨРӨЛ ЗҮЙЛ ӨРТӨХ ЭСЭХ

Газарт бууж буй тоос нь ургамлын аль нэг хэсэгт наалдаж улмаар өнгө зүс нь алдагдах, навч шилмүүсэнд нь түлэгдэлт үүсэх, навч нь эрт унах зэрэг байдал бий болдог байна. Ургамлын бүрхүүлийн энэхүү өөрчлөлт нь хүний нүдэнд ил харагдаж байдаг бол үүний цаана нүдэнд харагдахгүй ихээхэн өөрчлөлт орох, фотосинтезийн идэвхи буурах, өсөлт удаашрах улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих зэрэг байдал бий болдог.

АН, АМЬТАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ: - ЗЭРЛЭГ АМЬТДЫН АМЬДРАХ ОРЧИНГ ДОРОЙТУУЛАХ ЭСЭХ - ХОВОР БОЛОН НЭН ХОВОР АМЬТАН ӨРТӨХ ЭСЭХ

Барилга бүтээн байгуулалт, уурхайлалтын үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин устгах, жижиг амьтад үйл ажиллагаанд өртөж үхэж хорогдох, хүний үйл ажиллагааны улмаас амьтдын бүлгэмдэлд өөрчлөлт орох, улмаар зарим зүйл амьтдын тоо толгой, нүүдэл шилжилтэнд сөргөөр нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөтэй.

Хүснэгт 17. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шалгуурууд ба сөрөг нөлөөлөл үүсч болох шалтгаанууд

БҮЛЭГ IV. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилт:

- ✓ Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, гүний усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах арга хэмжээг авах
- ✓ Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичиг, стандартыг баримтлах
- ✓ Шаардлагатай хөрөнгө, зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох
- ✓ Техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх
- ✓ Дүйцүүлэн хамгааллын ажилаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн ажилчдын кемпд мод тарих, нөлөөллийн бүсийн иргэдэд өвөлжилтийн бэлтгэл хийхэд зориулж өвс
- ✓ Уурхайн техникийн зогсоолыг сайжруулах

№	Төлөвлөгөөний төрөл	Зардлын дүн
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	ҮАЗ
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,000,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2,500,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	0
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	0
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ҮАЗ
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	500,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	450,000
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	7,000,000
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	1,000,000
Төлөвлөгөөний нийт зардал		12,450,000

Хүснэгт 6. Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын нэгтгэл

БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
1	Агаарын чанар	Тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнөөс тоосжилт бага үүсгэх/ Уртын тээврийг бүтээлэгтэй явуулах, богино тээврийг цагт 20км/ц-ээс доош хурдтай явуулж хянах	Уурхайн бүс	Тухай бүр	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	Агаарын бохирдлын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага, MNS 4990:2015 Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага
2		Уурхайн техник, хэрэгслийг үзлэг оношилгоонд хамруулах	Уурхайн бүс	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
3		Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох агаарын бохирдлын төлбөрийг төлөх	Уурхайн бүс	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
4	Усны нөөц	Усны тоолуурын заалтыг сумын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчаар хянуулж, баталгаажуулж байх	Гүний худаг	Жилийн хугацаанд	Сар бүр	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	Усны тухай хууль, Усны тухай хуулийн 28,29,30-р зүйл, Ус бохирдуулсны төлбөрийн тухай

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2026

5		Ус ашиглалтын дүгнэлт гаргуулан, ус ашиглуулах гэрээг холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, ус ашиглалтын төлбөрийг төвлөрүүлэх	Уурхайн бүсэд	Гэрээний хугацаанд	Тухай бүр	Дотоод зардал	1,200,000	IV-р улиралд багтаан	хууль
6		Гүний худагт суурилуулсан тоолуурын бүрэн бүтэн байдалд хяналт тавих	Гүний худаг	Жилийн турш	Сар бүр	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
7	Хөрсөн бүрхэвч	Хог хаягдлын гэрээг холбогдох байгууллагатай хийж, хогны төлбөрийг төлөх	Тээврийн зам дагуу	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	II-р улиралд багтаан	Газрын тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
8		Орчны хог хаягдлаас хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж бүх нийтийн хог цэвэрлэгээг хуваарийн дагуу хийх	Уурхайн нийт талбайд	Тухай бүр	Хуваарийн дагуу	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
9		Техникийн зогсоолыг сайжруулах	Уурхайн бүс	Тухай бүр	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
		Нийт							

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Төслийн талбайд	га	0,2	1,000,000	IV-р улиралд багтаан	MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5918:2023
	Нийт				1,000,000		

Хүснэгт 8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

**БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

	Арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж
	1	2	3	4	5	6
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	Уурхайн орчинд	ш	50	1,000,000	III-р улиралд
2	Биотехникийн арга хэмжээ: Нөлөөллийн бүсийн иргэд малчидад өвөлжилтийн бэлтгэл хангаж өвс тэжээл өгөх	Орон нутагт	-	-	1,500,000	IV-р улиралд
	Нийт дүн				2,500,000	

БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Манай төслийн нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй учраас нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн олборлолт явуулах явцад төслийн эзэмшлийн талбайгаас түүх, соёлын дурсгалт олдворууд илрээгүй боловч төслийн үйл ажиллагааны үед газар дээр ямар нэг дурсгал илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоон энэ тухай орон нутгийн Засаг дарга, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

БҮЛЭГ Х. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Болзошгүй осол, саатал, техникийн гэмтэл, галын гэнэтийн аюул г.м үүсэх	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний сургалт мэдээлэл хийх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах	Уурхайн бүсэд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	Ш-р улиралд багтаан	Гамшигаас хамгаалах тухай хууль, 27.1
2		Галын булангуудын үзлэг хийж, багаж хэрэгслийн бүрэн байдлыг шалгах	Уурхайн бүсэд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	Ш-р улиралд багтаан	
4		Ажилчдад ХАБЭА-ны ажлын хувцасаар хангах	Уурхайн бүсэд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	Ш-р улиралд багтаан	
5		Уурхайн ажилчдад: Хөдөлмөр хамгаалал, Аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах, өдөр тутмын зааварчилгаа байнга өгөх	Уурхайн бүсэд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
Нийт дүн									
							0		

БҮЛЭГ XI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж		Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	Хог хаягдлыг түр цэгт хадгалах, сумын нэгдсэн цэгт гэрээний дагуу тээвэрлэх, баталгаажуулах	Уурхайн нийт талбайд	Жилд	Тухай бүрт	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
2		Энгийн хог хаягдлын сав нь шаардлага хангасан байх	Уурхайн талбайд	Жилд	Тухай бүрт	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
3	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг хадгалах сав аюултай хог хаягдлын тэмдэг тэмдэглэгээтэй байх	Уурхай талбайд	Жилд	1 удаа	Дотоод зардал	I V-р улиралд багтаан	
4		Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх	Уурхайн талбайд	Жилд	1 удаа	500,000	IV-р улиралд багтаан	
						500,000		

БҮЛЭГ XII. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Усны хими, микробиологи, хүнд металлын шинжилгээг өгөх	Гүний худаг, Малчны худаг	Улиралд	1 удаа	Дотоод зардал	150,000	IV-р улиралд багтаан	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт MNS13.060.50 Усны чанарын стандарт , MNS 0900 : 2005 Ундны ус.
2	Хөрсний шинжилгээ /Хөрсний чанар хими физикийн ерөнхий үзүүлэлт, хүнд металл/	Уурхайн орчинд	Улиралд	1 удаа	Дотоод зардал	150,000	IV-р улиралд багтаан	Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс
3	Агаарын чанарын хяналт шинжилгээ	Уурхайн орчин/карьер, кемп/	Улиралд	1 удаа	Дотоод зардал	150,000	IV-р улиралд багтаан	
						450,000		

**БҮЛЭГ XIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Нийт зардал	Хариуцсан албан тушаалтан	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
	1	2	3	4	5
1	Удирдлага зохион байгуулалт	Байгаль орчны аудит хийлгэх	7,000,000	Байгаль орчны мэргэжилтэн	2 Жилд 1 удаа
2		Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж ажиллах, орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах	Дотоод зардал	Нийт ажилчид	Жилд 1 удаа
3		БОМТ болон БОМТ биелэлтийн тайланг БОУАӨЯ-нд илгээх	Дотоод зардал	Байгаль орчны мэргэжилтэн	Жилд 1 удаа
4		Хугацаат төлбөр, хураамжийг төлөх	Дотоод зардал	Ня-бо	Тухай бүр
Нийт дүн			7,000,000		

**БҮЛЭГ ХІV. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД,
ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6
1	БОМТ-ний тайлангийн биелэлтийг танилцуулга	БОМТ-ний биелэлтийг тайлагнах	Жилд 1 удаа	Дотоод зардал	Байгаль орчны мэргэжилтэн	Орон нутагт
2	Нийгмийн хариуцлагын гэрээний тайланг хүргүүлэх	Орон нутагт хийгдсэн ажлын тайланг тайлагнах	Жилд 1 удаа	Дотоод зардал	Гүйцэтгэх захирал	Орон нутагт
3	Уулзалт, санал асуулга	БОМТ-ний биелэлтийг тайлагнах	Жилд 1 удаа	1,000,000	Байгаль орчны мэргэжилтэн, уурхайн ахлах	Орон нутагт
	Нийт дүн			1,000,000		

Худалдаа Хөгжлийн Банк

Огноо: 2026.04.20 10:06:37

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 338776532

Системийн огноо: 2026.04.20

Нэр: ТҮМЭНТАЛ ХХК

Илгээгч	Дансны дугаар: 406285909	Нэр ТҮМЭНТАЛ ХХК	Дүн 6,250,000.00 MNT	Ханш 1.00
/ зургаан сая хоёр зуун тавин мянган төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 90 Дансны дугаар MN780090100900013406	Банкны нэр Төрийн сан Нэр БО нөхөн сэргээх баталгаа	6,250,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга:

ЕВ -MV-022689 ТҮМЭН ТАЛ ХХК ДУ.ДЭЛГЭРХАНГАЙ БО НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН БАРЬЦАА 20260

Танд баярлалаа